



МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Метро бизнес төв, А блок 5 давхар
Д.Сүхбаатарын гудамж-13
Сүхбаатар дүүрэг, УБ 14201-0033
Утас: 30 42 58, Факс: (976-11) 32 77 20
Цахим хуудас: www.crc.gov.mn
Цахим шуудан: info@crc.gov.mn

2021. 09. 09 № 01/1583
танай -ны № -т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗАРТ, ҮНДЭСНИЙ АУДИТЫН
ГАЗАРТ, ИНГҮҮМЭЛ ЖАРГАЛАНТ
АУДИТ ХХК-Д

Зөвлөмжийн биелэлт хүргүүлэх тухай

Харилцаа Холбооны Зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад Үндэсний аудитын газар, Ингүүмэл жаргалант аудит ХХК санхүүгийн тайлангийн аудит хийж менежментийн захидлаар нийт таван зөвлөмж, нэг албан шаардлагыг хүргүүлсэн.

Тус зөвлөмжийн хүрээнд Харилцаа Холбооны Зохицуулах хороо нь 2021 оны 9 дүгээр сарын 07-ны байдлаар дараах арга хэмжээг авч ажиллаж байна.

Үүнд:

Зөвлөмж 1 ажлын хүрээнд:

Утга: Програм хангамжийн ашиглалтын төлбөрийг биет бус хөрөнгөөр бүртгэсэн,

2020 онд худалдан авсан байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд ашиглагддаг, систем нь жил бүр шинэчлэгдэн 1 хүртэлх жилийн хугацаатай програм хангамжуудыг Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хууль, ТӨБЗГ-ын холбогдох журам, 2020 оны эд хөрөнгийн тооллогын үр дүн, Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны 2021 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн “Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасч, актлах тухай” 08 тоот тогтоол, холбогдох хууль, журмын дагуу актлах хүсэлт гарган 2021 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 01/504 тоот албан бичгээр ТӨБЗГазарт хүргүүлсэн бөгөөд тус газраас 2021 он 6 дугаар сарын 16-ны өдрийн А-1/998 тоот “Зөвшөөрөл олгох тухай” хариу албан бичиг холбогдох хууль журмын дагуу үндсэн хөрөнгөөс хасч 2021 оны хагас жилийн тайланд тусган ажиллалаа.

2021 оны батлагдсан төсөв, үйл ажиллагааны хүрээнд худалдан авсан 1 хүртэлх жилийн хугацаанд ашиглагдах нийт 34,2 сая төгрөгийн өртөг бүхий програмуудыг биет бус хөрөнгийн шинж чанар агуулаагүй, ашиглалтын төлбөр гэж үзэн Ингүүмэл жаргалант аудит ХХК-ийн өгсөн зөвлөмжийн дагуу тайлант хугацааны зардлаар бүртгэн ажиллалаа. Програм хангамжтай холбоотой өөрчлөлтүүдийг НББОУС-38, бусад холбогдох стандарт, журамд заасны дагуу байгууллагын НББББ-т тусган нийцүүлэх ажлыг хийж байна.

Холбогдох баримтыг хавсаргав.

Зөвлөмж 2 ажлын хүрээнд:

Утга: Тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг хэрхэн хүлээн зөвшөөрөх нь тодорхойгүй, авлагын тооцоо нийлэхэд зөрүү үүсдэг байна,

Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 1995 оноос эхлэн олгож ирсэн. Энэ хугацаанаас эхлэн тусгай зөвшөөрлийн төлбөрийг гэрээнд заасны дагуу олгох тухай шийдвэр гарсан өдрөөс жилээр тооцон төвлөрүүлж, тухайн жилдээ орлогоор хүлээн зөвшөөрч ирсэн.

Гэвч 2015 оноос эхлэн зөвшөөрлийн төлбөрийн орлогыг аудитын зөвлөмжийн дагуу санхүүгийн жилээр буюу буюу 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгон бүртгэж эхэлсэн.

Энэ нь зөвшөөрөл эзэмшигчидтэй тооцоо нийлж зөвшөөрлийн төлбөрийн үлдэгдлийн баталгаа авах үед тусгай зөвшөөрлийн гэрээгээр төлөх дүн нь санхүүгийн жилээр тасалбар болгон бүртгэсэн дүнгээс зөрж илэрхийлэгддэг болсон. Үүнийг хэрхэн шийдвэрлэх талаар 2020 оны санхүүгийн аудит хийсэн Ингүүмэл жаргалант аудит ХХК-ийн өгсөн зөвлөмж болон бусад зөвлөмжүүдийг үндэслэн Хорооны даргын зөвлөлд танилцуулга хийн, НББББ, болон бусад эрхийн актуудад нийцүүлэн “Тусгай зөвшөөрлийн төлбөрийн шинж чанар, гэрээний шаардлага нь СТОУС 15-ын орлого хүлээн зөвшөөрөлт-Гэрээг тодорхойлох 15а, 15б заалтуудыг хангаж байна” гэх үндэслэлээр зөвшөөрлийн төлбөрийн орлогыг гэрээний дагуу тусгай зөвшөөрлийн жилээр тооцон тухайн жилд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэхээр шийдвэрлэн, тус хорооны 2021 оны хагас жилийн санхүүгийн тайландаа тусгай зөвшөөрлийн орлогыг гэрээний дагуу тусгай зөвшөөрлийн жилээр тооцсон дүнгээр хүлээн зөвшөөрч тусган ажиллалаа.

Зөвлөмж 3 ажлын хүрээнд:

Утга: Анхан шатны маягуудыг зааврын дагуу бүрэн хөтлөх,

Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн ААН, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын дагуу тооцооны нягтлан бодогч, нярав, хүний нөөцийн мэргэжилтэнгүүдийн хамт өөрийн байгууллагын онцлогт тохируулан цаг бүртгэл, жолоочийн тооцоо, эд хөрөнгийн тооллогын бүртгэлийн холбогдох өөрчлөлтүүдийг хийж, мөрдөн ажиллаж байна.

Холбогдох баримтыг хавсаргаа.

Зөвлөмж 4 ажлын хүрээнд:

Утга: Ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй хөрөнгө бүртгэлтэй байна,

Хорооны даргын 2021 оны 04 дүгээр сарын 29 өдрийн А/92 тоот тушаалаар эд хөрөнгийн үзлэг, тооллогын ажил гүйцэтгэх тухай тушаалын дагуу ажлын хэсэг байгуулгаждаг 2021 оны эхний хагас жилийн байдлаарх үндсэн хөрөнгөнд тооллогын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Үг ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн тооллогод 13,280,847,262.36 (арван гурван тэрбум хоёр зуун наян сая найман зуун дөчин долоон мянга хоёр зуун жаран хоёр төгрөг гучин зургаан мөнгө) төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгөнд тооллого шалгалт хийгдсэн бөгөөд Метро бизнес төвд байрлах төв officissyn тавилга эд хогшил, машин тоног төхөөрөмж, компьютерүүд болон Радио Давтамж Хяналтын төв буюу Орбит станцад байрлалтай хэмжилт, шалгалтын тоног төхөөрөмжүүд, компьютер, тавилга эд хогшлыг ажилтан бүрийн үндсэн

хөрөнгийн эд хариуцагчийн жагсаалттай тулган эд хариуцагчийн картын бүртгэлийг шинэчлэн бүртгэсэн.

2. 2021 оны батлагдсан төсвийн дагуу эхний хагас жилийн байдлаар худалдан авсан нийт 1,033,846,973.02 (нэг тэрбум гучин гурван сая найман зуун дөчин зургаан мянга есөн зуун далан гурван төгрөгт хоёр мөнгө) төгрөгийн хөрөнгийг санхүүгийн програмд бүртгэх, коджуулах, эд хариуцагчид хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан.
3. Тус хорооны 2020 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу ажлын хэсгийн гишүүд байгууллагын балансад бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан нийт 2,243,826,649.56 (хоёр тэрбум хоёр зуун дөчин гурван сая найман зуун хорин зургаан мянга зургаан зуун дөчин есөн төгрөгт тавин зургаан мөнгө) төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгөд холбогдох мэргэжилтнүүдийн хамт дахин хяналт шалгалт хийж, хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хэвийн ашиглагдах болон ашиглагдах боломжгүй болсон хөрөнгийг актлаж устгах, цаашид байгууллагын хэвийн үйл ажиллагаанд ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэх санал гаргасан. Үүнд:

Хөрөнгийн төрөл	Үлдэгдэл өртөггүй хөрөнгийн дүн	Актлах саналтай хөрөнгийн дүн	Дахин үнэлэх саналтай хөрөнгийн дүн
Машин төхөөрөмж	1,694,819,085.13	532,930,990.37	1,161,888,094.76
Тавилга эд хогшил	62,080,304.50	13,706,999.10	48,373,305.40
Программ хангамж	486,927,259.93	19,028,972.36	467,898,287.57
Нийт дүн	2,243,826,649.56	565,666,961.83	1,678,159,687.73

4. 2021 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн Өмч хамгаалах комиссын хуралдааны шийдвэрийг үндэслэн техникийн комиссыг шинэчлэн байгуулж, гишүүдийг томилон журамд өөрчлөлт оруулж, бүртгэх маягт, зааврыг гарган Хорооны даргын 2021 оны 7 дугаар сарын 09-ны өдрийн А/146 тоот тушаалаар баталсан.

Холбогдох баримтыг хавсаргав.

Зөвлөмж 5 ажлын хүрээнд:

Утга: Төсөөт байгууллагын үйл ажиллагаанд тохируулан УСНББОУС-ын дагуу НБББББ-ыг боловсруулан баталсан боловч тухайн баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд бүрэн нийцэхгүй байна.

Тус Хороо нь 2017 онд өөрийн байгууллагын онцлогт тохируулан холбогдох хууль тогтоомж, стандартыг үндэслэн НБББББ-ийг шинэчлэн боловсруулж баталсан бөгөөд 2020 оны 5 дугаар сараас эхлэн 1 жилийн хугацаатай нэвтрүүлж буй “Байгууллагын санхүүгийн болон биллинг программ хангамжуудыг нэгтгэсэн шинэ систем хөгжүүлэх” ажлын хүрээнд гарч ирж буй өөрчлөлтүүд, Ингүүмэл жаргалант

аудит ХХК-ийн өгсөн зөвлөмж, шинээр батлагдсан холбогдох дүрэм, журмын өөрчлөлтүүдийг тусган байгууллагын статус, онцлогт тохирсон НББББ-ыг шинэчлэн боловсруулах ажлыг хийж байгаа бөгөөд 2021 онд батлуулан нэвтрүүлэхээр ажиллаж байна. Ажлын явц 80 хувийн гүйцэтгэлтэй байна.

Зөрчил арилгах тухай албан шаардлага:

Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг цахим сайтад байршуулаагүй,

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд, ил тод, бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашдаа алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, байгууллагын дотоод хяналтыг сайжруулж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Г.Чинзориг, ерөнхий нягтлан бодогч Н.Халиунаа нарт даалгав.

Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтын дагуу байршуулаагүй нийт 2,326.2 сая төгрөгийн шийдвэрийн болон орлогын мэдээллийг 2020 оны шилэн дансны мэдээлэлд 2021 оны 5 дугаар сарын байдлаар бүрэн оруулж ажиллаа. 2021 оны 9 дугаар сарын байдлаар “Шилэн дансны тухай” хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд, ил тод, бүрэн байршуулж, хугацаа хоцролтгүйгээр биелэлтийг ханган ажиллаж байна. Зөвлөмжийн биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 01/890 тоот албан бичиг болон холбогдох баримтын хамт ЗГХЭГ, УАГ, Ингүүмэл жаргалант ХХК-д тус тус хүргүүлсэн болно.

З дугаар сарын мэдээллийг жишээгээр хавсаргав.

